**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/15 Ханх сум

Ханх сумын Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 6 дугаар бзлгийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 149 дүгээр зарлигаар баталсан “Улсын хил хамгаалалтад иргэдийн оролцуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Ханх сумын Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн 2024 оны нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж үр дүнг тооцож ажиллахыг Зөвлөлийн орлогч дарга, Хилийн 0117 дугаар салбарын захирагч, ахмад (А.Ёндонпэлжээ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Баттүвшин)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Л. ДАВААБАЯР

My doc-2024 Zahiramj

0707000053

Ханх сумын Засаг даргын 2024 оны
..04... сарын ..04..-ны өдрийн ..А/15.. тоот
захирамжийн ..01.. хавсралт

БАТЛАВ
ХАНХ СУМЫН СУМЫН ЗАСАГ ДАРГА, ХИЛ ХАМГААЛАХ ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, Л.ДАВААБАЯР

2024 оны ... дугаар сарын .....

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН ХИЛ ХАМГААЛАХ ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛ ХИЛИЙН ЦЭРГИЙН 0117, 0335 ДУГААР САЛБАРТАЙ 2024 ОНД УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: МУ-ын ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлиг, МУХТХ-ийг хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтад ард иргэдийн оролцоог сайжруулах, орон нутгийн байгууллага, ард иргэд, хилийн заставын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хилийн болон ХОД-ын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

2023 оны 04 дүгээр сарын 01 Баясгалант

| д/д | Хийгдэх ажил | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран ажиллах байгууллага | Төсөв зардал | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| Нэг:Засаг даргын тамгын газар | | | | | | |
| 1 | ХХТХЗ-ийн 2024 оны төлөвлөгөөг батлуулж захирамж гаргуулах | I Улирал | Засаг дарга Заставын дарга | ЗДТГ | - | ХХТХСЗ-ийн гишүүдийн хамтын үйл ажиллагаа сайжирна |
| 2 | Хилийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 50.1.5 дахь заалтыг үндэслэн төсөвийн тодотголоор болон бусад эх үүсвэрийг гаргаж шийдвэрлэх | Эхний хагас жил | Засаг дарга | ИТХ Засаг дарга | | |
| 3 | ХХТХЗ-ийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, ХХТХЗ-ийн ажлыг дүгнэн, цаашид авах арга хэмжээг тодотгох | Хагас жилээр | Засаг дарга Заставын дарга | ЗДТГ | - | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хилийн бүс зурваст аялал жуулчлал, байгалийн баялаг ашигладаг иргэдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Тухай бүр | Засаг дарга Заставын дарга | БОТ Багийн Засаг дарга нар | | |
| 5 | Гэрээгээр алба хаах залуучуудын судалгааг сумын ЗДТГ-аас авч сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүсийг хилийн заставт гэрээгээр алба хаалгах | Тухай бүр | Засаг дарга Заставын дарга | Багийн Засаг дарга | - | |
| 6 | Хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилээр хулгайлагдсан болон бэлчээрээр хил давж, алдагдсан малын асуудлыг шийдвэрлэх хяналт шалгалтыг сайжруулах | Тухай бүр | Засаг дарга Заставын дарга | ИТХ-ын дарга Ц Хэсэг Багийн дарга СГХУСАЗСЗ | 100.000 | Хилийн болон ХОД-ын зөрчил буурах |
| 7 | Улирал цаг агаарын байдлыг харгалзан хариуцсан хэсгийн малчдын судалгааг авч өвөлжилт хүндэрсэн тохиолдолд хилийн зурваст нутаглах айл, өрхөд ХХЕГ-ын даргын 2017 оны А/97 дугаар тушаалын дагуу зөвшөөрөл олгож нутаглуулах, | I,II улиралд | Засаг дарга Заставын дарга | ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар | - | |
| 8 | МУ-ын Засгийн газрын 200 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, "Бидний бахархал" сэдвийн хүрээнд Хүүхэд залуучуудын оролцоог идэвхижүүлэх, цэрэг эх оронч үзлээр төлөвлшүүлэх зорилгоор ЕБС-тай хамтарч, 9.10.11 ангийн сурагчдыг хилийн цэргийн застав, Боомтын үйл ажиллагаатай танилцуулж үйл ажиллагааг зохион байгуулах /аялал/ | IV сар | ЗДТГ-ын дарга Заставын дарга | Турт багийн Засаг дарга Сургуулийн захирал | 50.000 | |
| 9 | Хилийн зурвасын замыг тэмдэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | II улиралд | Заставын дарга ЗДТГ | Багийн Засаг дарга нар БОТ Тусгай хамгаалалт | 300.000 | |
| 10 | Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнийг хариуцсан хэсгийн хилийн инженерийн байгууламж, өвөлжилтийн бэлтгэл ажилд | Жилдээ | Заставын дарга Засаг даргын | ЗДТГ Багийн засаг дарга нар | - | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | оролцуулж, танхимийн сургалтад хамруулж, цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах | | тамгын газар | | | |
| 11 | Оны тэргүүний хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөл гишүүнийг шалгаруулж шагнаж урамшуулах | XII сард | Заставын дарга ЗДТГ | ЗДТГ Багийн засаг дарга, | - | |
| 12 | Хилийн цэргийн 0117, 0335 дугаар салбарт шинээр шилжин ирсэн офицер ахлагч нарын хүүхдүүдийг цэцэрлэг сургуульд бүрэн хамруулах | Тухай бүр нь | Заставын дарга Засаг даргын тамгын газар | ЗДТГ СӨБ ЕБС | - | |
| 13 | Сумын ЗДТГ, хилийн застав цэргийн 0257 дугаар ангийн хооронд шефийн холбоог сэргээн, хилчдийн үүрэг гүйцэтгэх нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | Жилдээ | ЗДТГ-ын дарга | Хилийн цэргийн 0257 дугаар ангий ЗДТГ | - | |
| 14 | ХХТХСЗ-ийн дэлгэрэнгүй судалгааг шинэчлэх | IV/10 | ЗДТГ | Нарийн бичгийн дарга, Заставын дарга | - | |
| 15 | Ерөнхий боловсролын сургуульд хилчдийн булан /танхим/ байгуулах | II улиралд | Засаг дарга ЗДТГ | ИТХ ЗДТГ Заставын дарга | 3.000.000 | |
| 16 | Хил орчмын оршин суугчдад ХТХ, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, МУ-ын ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлиг, бусад хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавих | Жилдээ | Засаг дарга заставын дарга | ХХТХЗ-ийн дарга гишүүд | - | |
| 17 | Хилийн болон ХОД-ын биелэлтийг сахиулахад дэмжлэг туслалцаа үзүүлж, сумын Засаг даргын Тамгын газраас шатахууны туслалцаа үзүүлэх (Салбар тус бүрт сард 30 литр түлш бензин олгох) | Сар бүр | Засаг дарга ЗДТГ | ЗДТГ Заставын дарга нар | 1.000.000 | |
| 18 | Улсын баяр наадам онцгой нөхцөл үүссэн үед хамтран ажиллаж хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгэх | Тухай бүр нь | Засаг дарга заставын дарга | ЗДТГ Цагдаагийн хэсэг | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | Хилийн салбарт махны агуулах шинээр барих тохижуулах | II улиралд | Засаг дарга ЗДТГ | ИТХ ЗДТГ Заставын дарга | 5.000.000 | |
| Хоёр:Хилийн Ханх шалган нэвтрүүлэх боомтод | | | | | | |
| 20 | Боомтын хотхонд жагсаалын талбай шинээр хийх | II улиралд | Засаг дарга Боомтын дарга | ЗДТГ ИТХ | 5.000.00 | |
| 21 | Боомтын үүдэнд хүндэтгэлийн дурсгалын зураг татуулах хилийн багана тэмдэг хийх | II улиралд | Засаг дарга Боомтын дарга | ЗДТГ ИТХ | | |
| Гурав:Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг | | | | | | |
| 22 | Хилийн бүс зурваст ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж үр дүнг тооцох | Жилдээ | Байгаль орчины ажилтан заставын дарга | Багийн засаг дарга Байгаль орчны тасаг | - | |
| 23 | Сумын байгаль хамгаалагчтай хамтран хилийн зурваст хамтарсан шалгалт хийх | 6-9 дүгээр сард | Заставын дарга БОАХ-ын ажилтан | Байгаль орчны тасаг | - | Хууль бусаар мод хийх үйлдэл, хулгайн ан таслан зогсоогдсон байна. |
| 24 | Хилийн цэргийн заставын байрлалд, үр тарьцыг бэлтгэн, “Тэрбум мод тарих” хөтөлбөрт нэгдэж салбартаа мод болон нарийн ногоо тарих | II, III улиралд | Заставын дарга | Байгаль орчны тасаг | 200.000 | |
| 25 | Ван толгойн чиглэлд хогийг цэвэрлэж шатаах | Жилдээ | Заставын дарга БОАХ мэргэжилтэн Багийн засаг дарга | ЗДТГ, Байгаль орчны тасаг, Багийн засаг дарга | | |
| 26 | Албаны амьтадыг арчлан хамгаалах, өвөлжөө хаваржааны газрыг сэргээн засварлахад хэрэглээний модны гоожин хөнгөлөх | Жилдээ | Заставын дарга БО-ны тасаг | ЗДТГ, Байгаль орчны тасаг, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 27 | Хилийн цэргийн салбар, хилийн харуулын түлшний модны гоожинд хөнгөлөлт үзүүлэх | II улиралд | Заставын дарга БО-ны тасаг | ЗДТГ, Байгаль орчны тасаг, | | |
| 28 | Боомтын албаны түлшний модны гоожин хөнгөлөлт үзүүлэх | II улиралд | Заставын дарга БО-ны тасаг | ЗДТГ, Байгаль орчны тасаг, | | |
| | Дөрөв:Сумын эмнэлэг | | | | | |
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр: | | | | | |
| 29 | Хилчид, ард иргэд болон тэдгээрийн эрүүл мэндийг сахиулах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэг явуулах | Тухай бүр нь | Заставын дарга СЭ-ийн дарга | Сумын эмнэлэг | - | |
| | Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: | | | | | |
| 30 | Эрүүл мэндийн зөвлөгөө багц сургалтуудыг зохион байгуулах | Тухай бүр | Заставын дарга СЭ-ийн дарга | Сумын эмнэлэг | | |
| 31 | Хүүхдийн товлолын дархлаажуулалтад бүрэн хамруулах | Жилдээ | Заставын дарга СЭ-ийн дарга | Сумын эмнэлэг | | Хүүхдэд бүрэн хамрагдсан байх |
| 32 | Заставын ЭМЗ-ын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор СЭ-т 7 хоногийн хугацаатай дадлага хийлгэх | Тухай бүр нь | Заставын дарга СЭ-ийн дарга | Сумын эмнэлэг | - | ЭМЗ-ч эмнэлэгийн анхан шатны мэдлэгтэй болсон байх |
| 33 | Заставт Эрүүл мэндийн зааварлагчийн үзлэгийн өрөөг тохижуулах, эмийн бүрдэлийг бүрдүүлэх | I,II улиралд | СЭ-ийн дарга Заставын дарга | Сумын эмнэлэг | - | Өвчин эмгэг, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байх |
| | Тав:Сумын Цагдаагийн хэсэг | | | | | |
| 34 | Турт 3 дугаар багт хилийн зөрчилд холбогдож болзошгүй, байгалийн баялаг олборлогсод, хулгайн ан хийх иргэдийн судалгаа гаргаж дүгнэлт хийж мэдээ мэдээлэл солилцож ажиллах | Тухай бүр нь | Заставын дарга Хэсгийн төлөөлөгч | Хэсгийн төлөөлөгч | - | |
| 35 | Нэн ховор амьтад болон малын хулгайн талаар мэдээ мэдээлэл дамжуулах солилцох | Жилдээ | Заставын дарга Хэсгийн төлөөлөгч | Хэсгийн төлөөлөгч | - | Хулгайн ан болон малын хулгай таслан зогсоогдоно |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Албан байгууллагатай хамтран Цахим гэмт хэрэгт холбогдохгүй байхад яриа таниулга хийх | Тухай бүр нь | Заставын дарга Хэсгийн төлөөлөгч | Хэсгийн төлөөлөгч | - | |
| Зургаа:Аялал жуулчлалын талаар | | | | | | |
| 36 | Хилийн зурваст байрладаг Бүрэнхаан (Мөнхсарьдаг) ууланд авирах аялах зорилгоор ирсэн жуулчдад түргэн шуурхай зөвшөөрлийг олгох | Тухай бүр | Заставын дарга | Тусгай хамгаалалтын газар | | |
| 37 | Жуулчны баазуудад хилийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг танилцуулж хөдөлгөөний тооцооны хуудас хөтлөх | Тухай бүр | Застав Боомтын дарга | Тусгай хамгаалалтын газар Багийн Засаг дарга Цагдаагийн хэсэг | 100.000 | |
| 38 | Аялал жуулчдын гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавих | Тухай бүр | Заставын дарга | Тусгай хамгаалалтын газар | | |
| Нийт дүн: | | | | 14.200.000 төгрөг | | |

ТӨЛӨВЛӨСӨН:
ХИЛ ХАМГААЛАХ ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА, ХИЛИЙН ЦЭРГИЙН 0117 ДУГААР САЛБАРЫН ЗАХИРАГЧ,
АХМАД А.ЁНДОНПЭЛЖЭЭ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГА ХИЛ ХАМГААЛАХ ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, Б.БААСАНСҮРЭН